



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 дугаар сарын 16 өдөр

Дугаар 16

Хэрлэн сум

XVI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 16 дугаар хуралдаан 2021 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 79,1 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1."Дулаан" дэн буудал,"Мандал бэл", "Саруул зам" авто жолооны сургалтын төвийн үйл ажиллагааг нээх эсэх талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

2.Давтан шинжилгээний талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3.Авто тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгооны талаар мэдээлэл танилцуулах,

АЗДТГ-ын ХОХБТХэлтэс

4.Сумдын мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар судлаач нарыг аймгийн төвд сургалтад хамруулах эсэх тухай хэлэлцэх,

Мал эмнэлгийн газар



ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.1.Хяналт, шалгалтын дүгнэлтийг үндэслэн шаардлага хангасан "Дулаан" дэн буудлыг тусгаарлах байрны нөөцөд бүртгэж бэлэн байдлыг хангуулахыг,

1.2.Хяналт, шалгалтын дүгнэлтийг үндэслэн халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж "Мандал бэл", "Саруул зам" авто жолооны сургалтын төвүүдэд нэг танхимд 5-аас илүүгүй хүнтэйгээр үйл ажиллагааг эхлүүлэхийг зөвшөөрөв,

/  / М.Бадамсүрэн
/  Д.Баттулга

Хоёр.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр-д:

2.1.Дорнод аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог халдвар хамгааллын дэглэмийг сахиж зохион байгуулахыг зөвшөөрөв,

2.2.Тээврийн хэрэгслийн үзлэг, оношилгоог халдвар хамгааллын дэглэм баримталж ажиллах удирдамж батлуулан мөрдүүлэх, сумдын Засаг дарга нарт хүргүүлэхийг,

Гурав.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Аюушмаа-д:

3.1.Мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар судлаач нарыг чадавхжуулах сургалтыг халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн зохион байгуулахыг,

3.2.Сургалтын үед халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэх тухай удирдамжийг боловсруулж батлуулж, мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг,

Дөрөв.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа-д:

4.1.Эрүүл мэндийн газрын даргын “Коронавирус илрүүлэх төлбөртэй түргэвчилсэн шинжилгээ авах тухай” тушаалын төслийг Улсын Онцгой комиссын дарга, Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайд, Авилгатай тэмцэх газрын даргад аймгийн Засаг даргын албан бичгээр хүргүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.2.Аймгийн Онцгой комиссоос ачаа тээвэрлүүлж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа нарт:

4.3.Аймгийн Онцгой комиссоос ачаа тээврийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.БАТТУЛГА